МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
http://www.mmhi.gov.mn

2018.09.04 № 01/2340

танай 2018.08.23 -ны № 5-2/5520 -т

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

"Тогтвортой хөгжлийн үзэл
баримтлал-2030" биелэлт
хүргүүлэх тухай

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудалд хамаарах Монгол Улсын "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д тусгагдсан зорилт, үйл ажиллагааны 2016, 2017 оны жилийн эцэс болон 2018 оны эхний хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.3, 2.1.4 дүгээрт тусгагдсан аж үйлдвэр болон эрдэс баялгийн салбарын 4 зорилтын 9 үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дүгнэсэн ба 2016-2020 он хүртэлх эхний үе шатны зорилтын хэрэгжилт 55.0 хувийн биелэлттэй байна.

Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангах зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны хэрэгжилт 40%, хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилтын хэрэгжилт 70%, геологийн салбарын хөгжлийг дэмжих зорилтын хэрэгжилт 70%, ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хэрэгжилт 40 хувийн тус тус биелэлттэй байна.

Хавсралт 16 хуудастай.

Д.СУМЪЯАБАЗАР

## “МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 2030”-ЫН ХЭРЭГЖИЛТ

### /2018 оны эхний хагас жилийн байдлаар/

| МУТХҮБ-2030 | Зорилт | I Үе шат, Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт | | Зорилтот түвшин /2020 он/ | Хүрсэн түвшин 2016 | Хүрсэн түвшин 2017 | Гүйцэтгэл, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2014 он | 2014 Түвшин | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, | 2.1.3 Аж үйлдвэрийн салбар Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын | Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын йлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах Т- Гадаад зээл 800,000.0 | Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар | Барилгын ажлын явц, хувиар | 30 | Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах | Төслийн нарийвчилсан техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах БНЭУ-ын Эксим банкны шаардлага хангасан Зөвлөх компаниудаас сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хураангуй жагсаалтад багтсан Энэтхэгийн компаниудад хүргүүлж, саналыг аваад байна. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ний ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэг, тендер зохион байгуулах үнэлгээний хороог байгуулахаар ажиллаж байна.Биелэлт 10% | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд БНЭУ-аас Монгол Улсын Засгийн газарт олгохоор шийдвэрлэсэн 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг “........ дэд бүтэц, хөдөө аж ахуйн болон бусад төсөл” байсныг “...аж үйлдвэр, дэд бүтэц, хөдөө аж ахуйн болон бусад төсөл” болгон нэмэлт өөрчлөлт оруулж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэж Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн | 1. Газрын тос боловсруулах үйлдвэр. “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах Зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг 2017 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын хооронд Энэтхэг Улсын Эксим банктай хамтран зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтад БНЭУ-ын “Инженер синдиалимитед” компани шалгарч УУХҮЯ болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 08 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт тавьж, дүгнэлт гаргах ЗГ-ын “Захиалагчийн инженер”-ээр шалгарсан Итали Улсын “КТ-Кинетикс техноложи” компани судалгааны ажлын шат бүрийн тайлан, дүгнэлт хийж Монголын талд техник, технологи, эдийн засгийн хувьд Зөвлөх үйлчилгээ үзүүлэн Энэтхэгийн талд санал, зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. БНЭУ-ын Зөвлөхийн ирүүлсэн НТЭЗҮ-ийн дундын тайланд тусгасан технологийн сонголт болон төсөвт өртгийн тооцоолол олон улсын жишиг өртгөөс харьцангүй өндөр |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ. | үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана | | – | | | | – | “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн” тухай 59 дугаар тогтоолыг баталсан. Биелэлт 100% | гарсан тул захиалагч болон Зөвлөхөөс зарим тооцооллыг дахин нягтлах тухай шаардлагыг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Үүний дагуу БНЭУ-ын Зөвлөхийн зүгээс нэмэлт тооцооллыг ТЭЗҮ-ийн тайланд тусган 2018 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн боловч тооцооллыг Зөвлөх компанийн зүгээс тавьсан шаардлагыг бүрэн хангахгүй байна гэж дүгнэсэн. УУХҮСайд, Сангийн яам, Гадаад харилцааны яам болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг БНЭУ-д 2018 оны 06 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд айлчлал хийж Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк болон Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Инженерс Индиа Лимитед компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, нарийвчилсан ТЭЗҮ-ийн ажлын явц, үйлдвэрийн технологийн сонголт болон төсөвт өртгийн талаар тус тус санал солилцсоны үр дүнд Энэтхэгийн тал Монголын талын санал болгосон технологийг сонгохоор болж, үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг хоёр улсын ЗГ хооронд байгуулсан 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд багтаан дахин тооцолол хийхээр нэгдсэн ойлголт, тохиролцоонд хүрсэн бөгөөд нарийвчилсан ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн. ГТБҮ-ийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | БНЭУ-ын Зөвлөх “Инженерс Индиа Лимитед” компанийн туслан гүйцэтгэгчээр шалгарсан МУ-ын “Престиж инженеринг” 2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 04 дүгээр саруудад үйлдвэрийн болон дамжуулах шугам хоолойн инженер-геологийн хайгуул, судалгааны ажил, байр зүйн зураглал, усан хангамжийн судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэн тайланг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн.<br>Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох Сайншанд сумыг үйлдвэртэй холбох 27 км урт төмөр зам, 18,2 км урт цахилгаан хангамжийн 110 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 110/10 Кв-ын 6.3 МВА-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16,63 км урт хатуу хучилттай авто зам барих төслүүдийн барилгын ажлыг 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Дорноговь аймгийн Алтанширээ суманд эхлүүлсэн бөгөөд 2019 оны 4 дүгээр улиралд багтаан хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. |
| | | Зэс хайлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх. Т-Хувийн хэвшлийн хөрөнгө | Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан | ТЭЗҮ-ийг боловсруулах сонгон шалгаруулалтыг явуулсан | 2.5 Хувийн хөрөнгө оруулалт | Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах | Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн "Төслийн нэгж байгуулах тухай" 107 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн | УУХҮ-ийн Сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн төслийн нэгжийн захирал томилогдсон. 2017 оны Төсвийн | 2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл<br>ЗГ-ын 2017 оны “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх тухай” 232 дугаар тогтоолыг баталж, Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх “Хэрлэн гол |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оруулалт 862,400.0 | зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | байна. | | | төсөвт тусган санхүүжүүлэхээр тогтсон. Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулагдан удирдамжийн дагуу ажиллаж байна. УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийн нэгж"-ийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг 2017 оны 09 дүгээр сард сонгон шалгаруулахаар тусгасан.Биелэлт 10% | тодотголоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.ЗГ-ын 2017 оны "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүйгээр эзэмшихээр шийдвэрлэсэн. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх боломжит хувилбаруудыг судалж байгаа ба энэ хүрээнд дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтыг зарлаж "Таван Лекс" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. ЗТХЯ, "Оюутолгой" ХХК болон "Монголын Төмөр Зам" ТӨХК-тай үйлдвэрийн байршилийн асуудлаар хэлэлцэж газрыг | дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах ТЭЗҮ, БОНҮ-г хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг БОАЖЯ, УУХҮЯ-нд даалгасан. Дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтыг зарлаж "Таван Лекс" ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан. УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/109 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барих талбайн байршлыг төмөр зам, ус, эрчим хүчний хангамж болон бусад дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох зорилгоор "Оюутолгой" ХХК-ын удирдлага болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай Өмнөговь аймагт уулзалт зохион байгуулсан. Мөн ЗББҮ барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт үндэсний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэхээр "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2018 оны 08 дугаар сарын 01-ны өдөр БХБЯ-нд хүргүүлсэн. Төслийн нэгжээс "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл"-ийг боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн тайланг |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | урьдчилсан байдлаар товлосон. Төсөлд шаардлагатай 150га газрыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах асуудлыг Ханбогд сумын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 04/05 тоот тогтоолоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан. Биелэлт 40% | 2018.05.20-нд хүлээн авсан бөгөөд Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулахаар ажиллаж байна. Мөн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн 2018 оны үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор тус төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр зарлан аж ахуйн нэгжүүдээс мэдүүлгийг хүлээн аваад байна. (50%) |
| | | Алт цэвэршүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх. /Төсөв тусгагдаагүй байна/ | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 0 | 0 | Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх | Алт цэвэршүүлэх үйлдвэр барьж байгуулах боломжийн талаар санал дүгнэлт боловсруулж байна. Монголбанкны Ерөнхийлөгчтэй болон холбогдох албан тушаалтнуудтай алт цэвэршүүлэх үйлдвэрийн талаар уулзалт зохион байгуулсан. Цаашид алт цэвэршүүлэх үйлдвэр барьж байгуулах асуудлаар Монголбанктай хамтарсан Ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. | Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А/98 хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр барьж байгуулах талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 3.Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төсөл.<br>"Алт-2" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд УУХҮС-ын2018 оны А/23 дугаар тушаалаар байгуулагдсан "Алт олборлох төрийн өмчит компани, Алтны сорьцын лаборатори болон алт цэвэршүүлэх үйлдвэр" байгуулах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.МУ-ын нутаг дэвсгэрт илэрсэн алтны үндсэн ордуудын байршлын зураглал (бүсчилсэн байдлаар), эзэмшигчдийн бүртгэл, мэдээлэл болон нөөцийн бүртгэлийн талаарх судалгааг АМГТГ-аас 2018.03.09-ний өдөр хүлээн авч, үйл |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Биелэлт 10% | Энэхүү ажлын хүрээнд Монголбанк, Швейцарь улсын ARGOR-HERAEUS S.A. компанийн төлөөлөлтэй Алт цэвэршүүлэх үйлдвэрийн суурь судалгааг хийлгэх асуудлаар уулзалт зохион байгуулж, тус судалгааны тайланг Монголбанкны захиалгаар ARGOR-HERAEUS S.A.компани боловсруулахаар тохиролцож, эдгээр байгууллагуудын хооронд хамтран ажиллах гэрээ хийгдсэн байна. Биелэлт 40% | ажиллагаандаа ашиглаж байна.<br>2. Монгол, Казакстаны Засгийн газар хоорондын комиссын хуралдааны үеэр Казакстаны талтай алт олборлох, боловсруулахад хамтран ажиллах чиглэлээр УУХҮ сайд болон холбогдох албан тушаалтнууд БНКазУ-д албан айлчлалыг 2017.03.27-31-ны өдрүүдэд хийж, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.<br>3. Алт цэвэршүүлэх, алт олборлох үйл ажиллагаа эрхлэх “Эрдэнэс Алт Ресурс” ХХК-г "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харъяанд байгуулах асуудлыг тус компанийн 2018.03.13-ны өдрийн ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.<br>4. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг Ажлын хэсгийн хүрээнд боловсруулсан.<br>5. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулга хийсэн.<br>6. “Алт олборлох төрийн өмчит компани, Алтны сорьцын лаборатори болон алт цэвэршүүлэх үйлдвэр” байгуулах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг удирдамжийн дагуу ажиллаж санал, дүгнэлт боловсруулсан.<br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийн технологийн сонголт хийх ажлын хүрээнд Стандарт хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар болон Монголбанкнаас аж ахуйн нэгжүүдийн алтны сорьцын мэдээ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүлээн авсан. Мөн Швейцарийн Аргор компанийн лабораторид хийгдсэн алтны агуулгыг тодорхойлсон дэлгэрэнгүй шинжилгээний үр дүнг хүлээн авсан. Тус ажлын хүрээнд "Баян Айраг Эксплорэйшн" ХХК-аас 45гр алтны дээж хүлээн авч БНКазУ-ын "Тау Кен Алтын" компанид хүргүүлэн лабораторын шинжилгээ хийлгүүлсэн.<br>Алт цэвэршүүлэх үйлдвэрийн хууль эрх зүйн орчныг боловсронгүй болгох хүрээнд "Үнэт металл, эрдэнийн чулууны боловсруулалт, түүний эргэлтийн тухай" хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮСайдын 2018 оны 06 дугаар сарын 15 өдрийн дугаар А/126 тоот тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд хуулийн төслийн боловсруулсан. Мөн Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааг хийж гүйцэтгэсэн ба Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг, тандан судалгааны хамт ХЗДХ-ын сайдад хүргүүлээд байна. |
| | | Байгалийн хий, нүүрс боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх. Т-607.5 | Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар71 | 0 | 0 | Санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэрийг гаргуулах | ЗГ-ын 2016 оны 107 дугаар тогтоолоор "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар шийдвэрлэж, УУХҮС-ын 2016 оны А/43 | ЗГ-ын 2016 оны 107 дугаар тогтоолоор "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар | 4.Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төсөл<br>Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх мөн тус төслийн "Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ"-ний |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судалгаа”, “Метанжуулах технологийн харьцуулсан судалгаа”-ны урьдчилсан ТЭЗҮ-ийн тайлангуудыг 2017 оны 01 дүгээр сард УУХҮЯ-нд ирүүлээд байна. ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2017 оны 4 дүгээр сард, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн ерөнхий үнэлгээний зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг 2017 оны 5 дугаар сард ирүүлнэ Биелэлт 70% | | дүгээр сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн тусгай хэрэгцээнд авсан. Төслийн 2018 оны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор “Улаанбаатар хотын байгалийн хийн түгээх шугам сүлжээний трасс, технологийн судалгаа” хийх зөвлөх үйлчилгээг үзүүлэх нээлттэй тендер зарласан бөгөөд 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдөр тендерийг нээнэ. Мөн хот доторх түгээх сүлжээг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлын хүрээнд 2-р бүс /гэр хорооллын/ БЗД, СХД, ЧД, ХУД, БГД-ын засаг даргын тамгын газартай хамтран гэр хорооллын айл өрх, хүн ам, гэр байшингийн нарийвчилсан тоог хүлээн авч тус судалгаа, мэдээллийн дагуу анхан шатны боловсруулалтыг хийж байна. БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпорац (CNPC)-ийн охин компани болох “Хуан Чү барилга угсралт, инженеринг” компани (HQC) болон “Хятадын газрын тосны шугам хоолой” компани (CPP)-ууд уг төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн бөгөөд хамтарсан уулзалтуудыг хийн ажиллаж байна. |
| | | **Зорилт 3-ын хэрэгжилт** | | | **Дүгнэлт. Хэрэгжсэн хувь 40** | | | | |
| | Зорилт 4. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул | Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд | Үйлдвэр ашиглалтад орох | Бүтээн байгуулалт эхэлсэн байна. | 0 | Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн | Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн ТЭЗҮ урьдчилсан ТЭЗҮ болон БОННҮ-ний дунд шатны тайланг 2016.12.14-ны өдөр | Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 01 сарын 28-нд ашиглалтанд | 1."Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн ТЭЗҮ-ийн тайланг 2017 оны дүгээр сард хүлээж авсан б БОННҮ-ний тайланг 2018 оны дүгээр улиралд хүлээж авахаар ажиллаж байна.Дэлхийн банкн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана. | анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах. Т- Төр, хувийн хэвшлийн түншлэл 100,000.0 | | | | үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах | УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/63 тоот тушаалаар байгуулагдсан "Зөвлөх компаниудын ажлын тайлан гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг"-т танилцуулж, хүлээлгэж өгсөн. Тус ажлын хэсгээс урьдчилсан ТЭЗҮ-ийн тайланг хэлэлцэн, цаашид Банкны ТЭЗҮ-д оруулах санал боловсруулж, Зөвлөх компани /Канад Улсын "ХАЭЧ" компани/-д хүргүүлдсэн. ТЭЗҮ болон БОННҮ-гийн эцсийн тайлангуудыг 2017 оны 07 дугаар сард бүрэн хүлээж авна.Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК нь евро стандартад нийцсэн, жилд 20 000 тонн ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, давтах аргын технологитой үйлдвэрийг ашиглалтанд оруулж, 2017.01.28-ны өдөр нээлтээ хийсэн. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг Герман Улсын "Shuler" компани, бусад дагалдах төхөөрөмжийг Итали улсад үйлдвэрлэж, нийлүүлсэн. | оруулсан. Үйлдвэрийн нээлтийн ажиллагаанд яам, агентлагийн төлөөлөл оролцов.Биелэлт 100% | "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн хүрээнд "Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг КанадУлсын "Hatch" компани хийж гүйцэтгэн 2017 оны 9 дүгээр сард УУХҮЯ-ны ХҮБГ болон ажлын хэсэгт танилцуулан холбогдох засваруудыг оруулж хүлээлгэн өгсөн. Мөн "Байгал орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ"-ний урьдчилсан судалгааны тайланг Монгол Улсын "Экотон" болон "Ажид", "Экосфер" ХХК-иудын түншлэлийн баг боловсруулсан ба Төмөртэйн ордын уурхайн нөлөөллийн бүсэд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын ИТХ-ын тогтоолоор иргэдэд газар олгосон асуудлыг шийдвэрлүүлэх, эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах шаардлага үүсч байгаатай холбогдуулан Дэлхийн банкны УУДБХОД Төслийн хүсэлтээр гэрээг 2018 оны 4 дүгээр улирал хүртэл хугацаагаар сунгаı ажиллаж байна.Мөн "Дарханı төмөрлөгийн үйлдвэр" ХК нь евр стандартад нийцсэн 20 мян.тн/жи хүчин чадалтай давтах аргын га бөмбөлгийн үйлдвэрийг 2017 он 01 сарын 28-нд ашиглалт оруулсан.<br><br>2.Эрдэнэтийн төмөрлөги үйлдвэрийн төсөл. 2. "Бэрэн гру ХХК нь Эрдэнэтийн төмөрлөги үйлдвэрийн цогцолборын төсл 2013 оноос хэрэгжүүлж эхэл |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Биелэлт 70% | | бөгөөд шингэн ширмийн үйлдвэрийн эхний ээлж болох 35м3 багтаамжтай 35.0 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай домен зуухны угсралтын ажлыг 2014 оны 11-р сард дуусгаж, туршилтын ажлыг гүйцэтгэсэн ба хоёрдугаар ээлж буюу 70 м3 багтаамжтай 70.0 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай домен зуухыг 2018 онд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Цогцолборын ган хайлах, цутгах болон цувимал бүтээгдэхүүн /200 мян.тн/жил/ -ий үйлдвэрийн барилга, байгууламжийн угсралтын ажлыг дуусгасан. Тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг 2016 оны 5-р сард эхлүүлсэн ба 2019 оны 2 дугаар улиралд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэр ашиглалтад орсноор барилгын арматурын дотоодын хэрэгцээний 70 %-ийг хангах юм. |
| | | **Зорилт 4-ий хэрэгжилт** | | | **Дүгнэлт. Хэрэгжсэн хувь 70** | | | | |
| | 2.1.4.ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР Зорилт 1. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ. | Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, | 0 | 0 | 0 | Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, заавырг олон улсын хэмжээнд | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Монгол орны баруун хэсэгт ашигт малтмалын томоохон орд олох зорилгоор Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудын нутгийн хэмжээнд Баруун Монголын цул сульфид-2013 төслийг хэрэгжүүлж эцсийн суурин боловсруулалтын ажилтай танилцаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх | Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын 2017 оны А/96 дугаар тушаалаар батласан. Төслүүдийн хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалд тодотгол хийж А/241 дүгээр тушаалаар батлан | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны ХХ-2018-05-01 дугаар хуралдаанаар "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж" боловсруулах асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэсэн. Үүний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/195 дугаар тушаалаар "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж"-ийг голлох ашигт малтмалын төрлүүдээр боловсруулан |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | заавpыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрий | | | | хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах | бэлтгэл ажлыг ханган ажилласан. Сансрын зургийн тайлалт, Газрын ховор элементийн металлогени, Монгол орны металлогени зэрэг төслүүдийн суурин боловсруулалтын ажлууд хийгдсэн. Үр дүнгийн тайланг 2017 онд хүлээн авна. Геологийн судалгааны ажилд орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах, ОУ-ын хэмжээнд хүргэх зорилгоор ASTER төрлийн хиймэл дагуулын мэдээллийг боловсруулах Сансрын зургийн тайлалт-2013 төслийн суурин боловсруулалтын ажилтай танилцсан.Биелэлт 30% | хэрэгжилтийг ханган ажиллав. Төслүүдийн 2017 оны хээрийн судалгааны ажлын үр дүн-анхдагч материалыг хүлээн авсан. Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлтгэсэн. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13,2 хувь хамрагдна.Биелэлт 70% | хэрэгжүүлэх, ажлын уялдааг хангах үүднээс редакцийн зөвлөл болон төслийн даалгаврыг баталсан. Тушаалын хэрэгжилтийн дагуу шороон орд, хайлуур жонш, алт, төмөр, газрын тос гэсэн 5 төрлөөр аргачилсан заавар, зөвлөмж боловсруулахаар ажиллаж байна. Дээрх 5 ашигт малтмалын төрлөөр аргачилсан заавар, зөвлөмж боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажиллаж байна.<br>Уран, нүүрс гэсэн 2 ашигт малтмалын төрлөөр аргачилсан зөвлөмжийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. |
| | | | Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх | Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь | 2016 онд 100 хувь хамруулсан байна | Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулах | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 86%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2016 онд УГЗ-200-Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V, Төв Монгол-VI төслүүдийн суурин боловсруулалтын ажлыг хэрэгжүүлж дууссан. Үр дүнгийн | УГЗ-200-Төв Монгол-VI төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, сайдын 2017 оны А/108 дугаар тушаалаар хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн 90%-д 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлыг бүрэн гүйцэтгээд | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлын хүрээнд УГЗ-200-Төв Монгол-VI төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, сайдын 2017 оны А/108 дугаар тушаалаар хүлээн авсанбол УГЗ-200-Төв Монгол-V төслийн үр дүн ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн 94%-д 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлыг бүрэн гүйцэтгээд байна.Үлдсэн 6%-ийг хамарч буй Дорнод Монгол-VI, VII, төслүүдийн үр дүнгийн тайланг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | н 40 хувьд гүйцэтгэх. Т-11.8 Улсын төсөв | | | | тайланг 2017 онд хүлээн авснаар 100% хамрагдаж дуусна. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн.Биелэлт 10% | байна.Үлдсэн нутаг дэвсгэр буюу 10%-ийг хамарч буй УГЗ-200 зураг зохиох ажлын хүрээнд Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг “К” хавтгайн хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Уг төслийн 2017 оны төлөвлөгөө, төсвийг сайдын 2017 оны А/96 дугаар тушаалаар, төлөвлөгөө, төсвийн тодотголыг А/241 дүгээр тушаалаар тус тус батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Мөн төслийн 2017 оны хээрийн судалгааны ажлын үр дүн-анхдагч материалыг хүлээн авсан. Биелэлт 70% | ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын арга аргачлал, хэмжээ, төсвийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, УУХҮС-ын А/154 дүгээр тушаалаар батласан. Төслийн 2018 оны хээрийн судалгааны ажил эхэлсэн бөгөөд энэ онд К хавтгайн нутаг дэвсгэрийн 25%-ийг хамруулна. |
| | | | Геологийн 1:50000-ны масштаб | Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, | 36 | Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, | 2016 онд Тогоо хайрхан-50, Улаанбадрах-50, Баяндалай-50, Онц уул-50, Эмээлцэгийн | Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн Монгол Алтай-50, Ар | 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын үр дүнгийн тайлантай 11 төслөөс Цогт-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах | хувь | | сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх. | нуруу-50 төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 34.6%-ийг хамруулсан. Тайлант онд суурин болон хээрийн судалгааны ажилтай 23 төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Шинээр хэрэгжүүлэх 10 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлснээр нутаг дэвсгэрийн 5%-д ажил үргэлжлэн хэрэгжиж байна. 2017 онд нутаг дэсвгэрийн 1.5%-д төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажилласан. Биелэлт 10% | чулуут-50, Хайрхан уул-50, Дөрөө нуур-50, Булган-50, Буурал хайрхан-50, Тойромын хөндий-50, Хөх нуур-50, Тахилт-50, Эргэлийн зоо-50, Алтайн нуруу-50, Дэлгэрхаан-50 төслүүдийн дуусгав. Төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн дүгнэлтийг гаргуулсаны үндсэн дээр сайдын А/02, А/56, А/57, А/59, А/60, А/61, А/106, А/107, А/134, А/135, А/170, А/171 дүгээр тушаалуудаар хүлээн авсан. 2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн судалгааны ажлаар нийт нутаг дэвсгэрийн 37,4%-ийг бүрэн бүрхсэн. Биелэлт 70% | Хөхөлзөгийн говь-50, Бударын чулуу-50, Шивээт уул-50 /нийт-7/ төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 38.7%-ийг бүрэн хамруулсан. Төлөвлөгөөт онд 18 төслийг нутаг дэвсгэрийн 4%-д хэрэгжүүлэн ажиллахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Ингэснээр үр дүнгийн тайлантай болон үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийг хэрэгжүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 42.7%-ийг судалгаанд хамруулж Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгнө. |
| | | **Зорилт 1-ийн хэрэгжилт** | | | **Дүгнэлт. Хэрэгжсэн хувь 40** | | | | |
| | Зорилт 2. Ил тод, хариуцлагатай олборлох | Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой | Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөр | Гэрээний хэрэгжилтийг дүгнэн, гэрээнд өөрчлө | 0 | Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг | Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах 3 хувилбар бүхий санал боловсруулж, ордыг олон улсын консерциумтай | Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх зорилгоор харьцуулсан судалгаа хийж, санал дүгнэлт, | Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол батлуулсан. Уг тогтоолоор Тавантолгойн нүүрсний |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах. Т-2,600,000.0 | үүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | лт оруулах асуудлыг шийдвэрлэсэн байна. | | хангах | хамтарсан хэлбэрээр ашиглах нь оновчтой гэсэн санал гаргасан.<br>- Тавантолгойн ордыг дэд бүтцийн хамт иж бүрнээр нь ашиглалтад оруулах талаар хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 104 дүгээр захирамжаар шинээр байгуулагдаж хэлэлцээр хийгдэж байна.<br>-Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглахтай холбогдон, Уул уурхайн яам /Эрдэнэс тавантолгой ХК/ болон Япон улсын НЕДО байгууллага /Нагата инженеринг/ хамтран Тавантолгойн ордыг түшиглэн нүүрсийг хуурай аргаар баяжуулах туршилтын үйлдвэр байгуулах тухай санамж бичгийг байгуулсан ба уг төслийн ажлыг тус яам үргэлжлүүлж байна.<br>-Төслийн үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлүүлэх талаарх хууль эрхзүйн орчны судалгааг хийж | зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/67-р тушаалаар байгуулан Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК -тай хамтран орд ашиглах харьцуулсан тооцоо, судалгаа хийж Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах боломжит хувилбарыг боловсруулсан. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 0-р давхаргын нүүрстэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун хэсгийн 3, 4, 0-р давхаргын чанар муутай нүүрсийг хольж баяжуулан үр дүнг тодорхойлох үүргийг УУХҮ-ийн сайдаас Эрдэнэс Таван Толгой болон Энержи Ресурс компаниудад өгсний дагуу тус компаниуд анхдагч хэлэлцээрийг эхлүүлээд байна.<br>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, | ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, /Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Оюутолгой-Ханги, Тавантолгой-Баруун наран чиглэлийн автозамын төгсгөлөөс Цагаан дэлүүл чиглэлийн тусгай зориулалтын автозам болон Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам зэрэг төслийг эхлүүлэх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн эрчим хүчний хэрэгцээг хангах цахилгаан станц болон нүүрс химийн үйлдвэрийг Тавантолгойн ордыг түшиглэн барих талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар даалгасан болно. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сангийн яам болон Татварын ерөнхий газарт санал боловсруулж хүргүүлэхээр бэлтгэсэн. Биелэлт 10% | Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Л.Энхболд нарын хамт 2017 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Таван толгойн бүлэг ордод олборлолт, баяжуулалт хийж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсаны дагуу "Таван толгойн ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх тухай" ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулж холбогдох байгууллага, яамдаас санал авахаар хүргүүлээд байна.40 | |
| | | **Зорилт 2-ын хэрэгжилт** | | | **Дүгнэлт. Хэрэгжсэн хувь 40** | | | | |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ